



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/378

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.АНУ-ын Батлан хамгаалахын атташейн албаны Цэргийн иргэн харилцааны санхүүгийн асуудал хариуцсан ажилтан Жеррими Барбор, Цэргийн иргэн, харилцааны эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтан Маттью Митотой хийсэн хамтын ажиллагааны санал солилцох уулзалтын зардалд 464 200 төгрөг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд хүрэлцэн ирж үнэ төлбөргүй зөвлөгөө өгч, үзлэг хагалгаа хийж ажилласан АНУ-ын нүдний нарийн мэргэжлийн эмч нартай хийсэн уулзалтын зардалд 176 500 төгрөг, Солонгосын Койка олон улсын байгууллагын сайн дурын гишүүдтэй цаашдын хамтын ажиллагааны талаар хийсэн уулзалтын зардалд 164 000 төгрөг, БНХАУ-ын Аньхуй мужтай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах арга хэмжээний зардалд 590 000 төгрөгийг тус тус хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 1 394 700 төгрөг /Нэг сая долоон зуун ерөн дөрвөн мянга долоон зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг Даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/378 Ch

02 01960

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар  
сарын 17-ны өдрийн А/378 дугаар  
захирамжийн хавсралт

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН  
БАЙГУУЛСАН АРГА ХЭМЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д.д	Зардлын төрөл, зүйл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1. АНУ-ын Батлан хамгаалахын атташейн албаны Цэргийн иргэн харилцааны санхүүгийн асуудал хариуцсан ажилтан Жеррими Барбор тэргүүтэй хүмүүстэй хийсэн уулзалтын төсөв.					
1	Бэлэг дурсгал	ш	5	40.000	200.0
2	Санал солилцох уулзалтын арга хэмжээний зардал	ш	10	26.420	264.2
	Дүн				464.2
2. АНУ-ын нүдний нарийн мэргэжлийн эмч нартай хийсэн уулзалтын төсөв.					
3	Бэлэг дурсгал	ш	6	17.000	108.0
4	Уулзалтын цайны зардал	ш	10	6850	68.5
	Дүн				176.5
3. Солонгосын Койка олон улсын байгууллагын сайн дурын гишүүдтэй цаашдын хамтын ажиллагааны талаар хийсэн уулзалтын төсөв.					
5	Бэлэг дурсгал	ш	5	32.800	164.0
	Дүн				164.0
4. БНХАУ-ын Аньхуй мужтай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах арга хэмжээний төсөв					
6	Бэлэг дурсгал	ш	10	59.000	590.0
	Дүн				590.0
	НИЙТ ДҮН				1 394.7

-oOo-